



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/186/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Гийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
САОНӨГ	Сэлэнгэ аймгийн орон нутгийн өмчийн газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	371,867,907.88	637,217,320.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	195,676,782.88	446,119,195.05
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	195,676,782.88	446,119,195.05
3121	Төгрөг	195,676,782.88	446,119,195.05
31211	Төрийн сангийн харилцах	195,676,782.88	446,119,195.05
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	176,191,125.00	191,098,125.00
351	Түүхий эд материал	11,318,710.18	11,318,710.18
3511	Тусгай зориулалттай материал	11,318,710.18	11,318,710.18
353	Бэлэн бүтээгдэхүүн		1,434,350.00
354	Хангамжийн материал	164,872,414.82	178,345,064.82
3541	Бичиг хэргийн материал	268,500.00	
3546	Хүнсний материал		1,202,500.00
3547	Бусад хангамжийн материал	164,603,914.82	177,142,564.82
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,734,063,057.51	1,782,199,532.15
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,734,063,057.51	1,782,199,532.15
392	Биет хөрөнгө	1,669,457,857.39	1,707,652,332.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,462,695,073.12	1,477,695,073.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-282,861,351.43	-348,686,114.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,562,500.00	-14,562,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	448,525,091.11	605,967,616.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-131,221,025.10	-216,341,418.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	142,545,863.89	172,864,863.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-66,406,919.16	-86,439,336.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,548,557.80	51,398,557.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,116,323.55	-20,758,729.50
39217	Ном	67,748,890.71	71,951,819.91
393	Биет бус хөрөнгө	64,605,200.12	74,547,200.12
39301	Програм хангамж	1,500,000.00	16,656,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-999,999.88	-1,299,999.88
39303	Бусад биет бус хөрөнгө	64,105,200.00	59,191,200.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,105,930,965.39	2,419,416,852.20
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	339,141.57	1,228,521.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	339,141.57	1,228,521.22

413	Өглөг	339,141.57	1,228,521.22
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	339,141.57	1,228,521.22
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,105,591,823.82	2,418,188,330.98
51	Засгийн газрын хувь оролцоо	2,105,591,823.82	2,418,188,330.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	524,860,423.90	524,860,423.90
51101	Өмч: - төрийн	524,860,423.90	524,860,423.90
512	Хуримтлагдсан үр дүн	-208,974,546.63	103,621,960.53
5121	Өмнөх үеийн үр дүн	-208,974,546.63	-208,974,546.63
5122	Тайлант үеийн үр дүн		312,596,507.16
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,789,705,946.55	1,789,705,946.55
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,105,930,965.39	2,419,416,852.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөгөөр/	
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,459,833,530.84	3,505,603,702.20		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	278,620,630.84	324,028,702.20		
120	Нийтлэг татварын бус орлого	278,620,630.84	324,028,702.20		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,737,562.00	14,956,090.00		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,639,062.00	3,764,800.00		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,098,500.00	11,191,290.00		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	221,679,231.22	153,841,054.20		
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	33,203,837.62	155,231,558.00		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,181,212,900.00	3,181,575,000.00		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,884,537,700.00	2,902,339,300.00		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,884,537,700.00	2,902,339,300.00		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих				
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		19,955,000.00		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,955,000.00		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	296,675,200.00	259,280,700.00		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	296,675,200.00	259,280,700.00		
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				

II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,257,403,014.62	3,188,093,195.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,257,403,014.62	3,188,093,195.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,155,932,514.62	3,076,857,645.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,410,730,269.22	2,018,582,395.00
210101	Үндсэн цалин	978,738,728.08	2,016,937,817.00
210102	Нэмэгдэл	398,537,294.17	1,644,578.00
210104	Урамшуулал	33,454,246.97	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,504,609.93	245,928,799.42
210201	Тэтгэврийн даатгал	124,614,423.73	168,007,002.20
210202	Тэтгэмжийн даатгал	14,195,443.41	20,258,216.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,135,974.65	10,284,878.63
210204	Ажилгүйдлийн даатгал	2,679,029.57	9,475,620.61
210205	Эрүүл мэндийн даатгал	26,879,738.57	37,903,081.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	249,121,741.57	252,277,479.65
210301	Гэрэл, цахилгаан	20,048,191.59	23,204,854.76
210302	Түлш, халаалт	221,956,109.98	221,955,184.89
210303	Цэвэр, бохир ус	7,117,440.00	7,117,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	85,390,300.00	99,047,900.00
210502	Хоол, хүнс	85,390,300.00	99,047,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,932,000.00	7,892,600.00
210604	Урсгал засвар	27,932,000.00	7,892,600.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,243,624.00	25,239,709.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,003,624.00	3,764,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,240,000.00	21,474,909.41
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,009,969.90	427,888,761.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,182,026.02	229,560,482.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,154,678.13	22,408,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,673,265.75	175,919,979.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,470,500.00	111,235,550.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,470,500.00	111,235,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	101,470,500.00	111,235,550.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	202,430,516.22	317,510,507.16

145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,384,204.91	4,914,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,384,204.91	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		4,914,000.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-8,384,204.91	-4,914,000.00
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	194,046,311.31	312,596,507.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/төгрөгөөр/
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,204,950,462.00	3,196,531,090.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23737562	14956090
120	Нийтлэг татварын бус орлого	23737562	14956090
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,639,062.00	3,764,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,098,500.00	11,191,290.00
120009	Бусад орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,181,212,900.00	3,181,575,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,884,537,700.00	2,902,339,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,884,537,700.00	2,902,339,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		19,955,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,955,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	296,675,200.00	259,280,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	296,675,200.00	259,280,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,133,154,707.55	2,870,959,277.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,133,154,707.55	2,870,959,277.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,031,684,207.55	2,758,289,377.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,410,730,269.22	2,018,582,395.00
210101	Үндсэн цалин	978,738,728.08	1,255,326,577.95
210102	Нэмэгдэл	398,537,294.17	721,996,717.05
210104	Урамшуулал	33,454,246.97	41,259,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,504,609.93	245,928,799.42

210201	Тэтгэврийн даатгал	124,614,423.73	168,007,002.20
210202	Тэтгэмжийн даатгал	14,195,443.41	20,258,216.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,135,974.65	10,284,878.63
210204	Ажилгүйдлийн даатгал	2,679,029.57	9,475,620.61
210205	Эрүүл мэндийн даатгал	26,879,738.57	37,903,081.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	248,782,600.00	251,388,100.00
210301	Гэрэл, цахилгаан	19,709,050.02	22,315,475.11
210302	Түлш, халаалт	221,956,109.98	221,955,184.89
210303	Цэвэр, бохир ус	7,117,440.00	7,117,440.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	84,610,400.00	100,250,400.00
210502	Хоол, хүнс	84,610,400.00	100,250,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,932,000.00	7,892,600.00
210604	Урсгал засвар	27,932,000.00	7,892,600.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,088,624.00	25,239,709.41
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,003,624.00	3,764,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,085,000.00	21,474,909.41
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,035,704.40	109,007,374.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,950,056.40	86,599,074.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,085,648.00	22,408,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,470,500.00	112,669,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,470,500.00	112,669,900.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	101,470,500.00	112,669,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	71,795,754.45	325,571,812.17
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	71,207,400.00	75,129,400.00
	Дотоод эх үүсвэрээр	71,207,400.00	75,129,400.00
222001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	71,207,400.00	75,129,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-71,207,400.00	-75,129,400.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	588,354.45	250,442,412.17

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	195,088,428.43	195,676,782.88
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	195,676,782.88	446,119,195.05

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	524,860,423.90	1,789,705,946.55	-208,974,546.63	2,105,591,823.82
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			312,596,507.16	312,596,507.16
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	524,860,423.90	1,789,705,946.55	103,621,960.53	2,418,188,330.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,394,453,600.00	2,946,088,677.83	448,364,922.17	86.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,394,453,600.00	2,946,088,677.83	448,364,922.17	86.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,267,550,900.00	2,833,418,777.83	434,132,122.17	86.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,334,232,600.00	2,018,582,395.00	315,650,205.00	86.5
210101	Үндсэн цалин	1,513,485,600.00	1,255,326,577.95	258,159,022.05	82.9
210102	Нэмэгдэл	804,818,200.00	721,996,717.05	82,821,482.95	89.7
210104	Урамшуулал	15,928,800.00	41,259,100.00	-25,330,300.00	259.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,778,900.00	245,928,799.42	45,850,100.58	84.3
210201	Тэтгэврийн даатгал	198,409,600.00	168,007,002.20	30,402,597.80	84.7
210202	Тэтгэмжийн даатгал	23,342,200.00	20,258,216.02	3,083,983.98	86.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,671,200.00	10,284,878.63	1,386,321.37	88.1
210204	Ажилгүйдлийн даатгал	11,671,200.00	9,475,620.61	2,195,579.39	81.2
210205	Эрүүл мэндийн даатгал	46,684,700.00	37,903,081.96	8,781,618.04	81.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	251,388,100.00	251,388,100.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	19,779,800.00	22,315,475.11	-2,535,675.11	112.8
210302	Түлш, халаалт	221,954,700.00	221,955,184.89	-484.89	100.0
210303	Цэвэр, бохир ус	9,653,600.00	7,117,440.00	2,536,160.00	73.7
2104	Хангамж, бараа материалын зардал			0.00	

2105	Нормативт зардал	119,460,100.00	100,250,400.00	19,209,700.00	83.9
210502	Хоол, хүнс	119,460,100.00	100,250,400.00	19,209,700.00	83.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,892,600.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	7,892,600.00	7,892,600.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал			0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,810,100.00	40,395,709.41	22,414,390.59	64.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,800,000.00	3,764,800.00	35,200.00	99.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,010,100.00	36,630,909.41	22,379,190.59	62.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	199,988,500.00	168,980,774.00	31,007,726.00	84.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	177,580,200.00	146,572,474.00	31,007,726.00	82.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,408,300.00	22,408,300.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,902,700.00	112,669,900.00	14,232,800.00	88.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,902,700.00	112,669,900.00	14,232,800.00	88.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	126,902,700.00	112,669,900.00	14,232,800.00	88.8
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,394,453,600.00	3,196,531,090.00	197,922,510.00	99.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,093,417,900.00	2,902,339,300.00	191,078,600.00	100.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,902,339,300.00	2,902,339,300.00	0.00	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	191,078,600.00		191,078,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		19,955,000.00	-19,955,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		9,955,000.00	-9,955,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00	-10,000,000.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	259,280,700.00	259,280,700.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	259,280,700.00	259,280,700.00	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	41,755,000.00	14,956,090.00	26,798,910.00	35.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,800,000.00	3,764,800.00	35,200.00	99.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,955,000.00	11,191,290.00	26,763,710.00	29.5
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		195,676,782.88	-195,676,782.88	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		446,119,195.05	-446,119,195.05	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль нь “Суралцахуйн суурь чадвар эзэмшсэн, эерэг харилцаа, эрүүл зөв дадалтай суралцагч” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах боломж, нөхцөлийг бүрдүүлж, сургууль завсардалгүй сургах;
- Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, цахим хичээл болон даалгаврын сан бүрдүүлэн ашиглах;
- Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүйгээ хөгжүүлж, хамтран ажиллах;
- Суралцагчдын бие даах чадварыг хөгжүүлж, хамтран суралцах үйл ажиллагааг дэмжин ажиллах;
- Багш, ажилтан, суралцагчдын сэтгэл зүйг дэмжин, стрессээс ангид байлгаж, эрүүл мэндийг дэмжин ажиллах;
- Багш ажилтны ажиллах эрүүл таатай, ээлтэй орчныг бүрдүүлэн ажиллах;
- Багш, удирдах ажилтан, ажилчдын ёс зүй, хариуцлага хамтын ажиллагааг сайжруулах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,419,416.9 мянган төгрөг болж өмнөх оноос 313,485.9 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	195,676.8	446,119.2	250,442.4
Авлага			
Бараа материал	176,191.1	191,098.1	14,907.0
Үндсэн хөрөнгө	1,734,063.1	1,782,199.5	48,136.5
Нийт хөрөнгө	2,105,931.0	2,419,416.9	313,485.9
Өр төлбөр	339.1	1,228.5	889.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,105,591.8	2,418,188.3	312,596.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,105,931.0	2,419,416.9	313,485.9

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 446,119.2 мянган төгрөг болж 250,442.4 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас;
- Бараа материалын дансны үлдэгдэл 191,098.1 мянган төгрөг болж 14,907.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 285,836.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 155,231.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 426,161.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,470,287.6 мянган төгрөг болж 224,056.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 75,129.4 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авч, хандив тусламжаар 153,841.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, аймгийн ИТХ-ын 2024 оны 04 сарын 02-ны өдрийн 160 дугаар тогтоолоор 4,914.0 мянган төгрөгийн үнэ бүхий газрыг сумын ЗДТГ-т балансаас балансад шилжүүлсэн зэрэг нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 688,088.1 мянган төгрөг бөгөөд 1,782,199.5 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 1,228.5 мянган төгрөг болж 889.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 11 сард цахилгааны үнэ нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 2,871,157.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 354,187.6 мянган төгрөг, нийт 3,225,344.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 501,485.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 52,799.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 16,942.5 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 3,868.5 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 42,107.4 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 96,187.8 мянган төгрөгөөр нийт 713,391.1 мянган төгрөгөөр бууруулж, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 1,897.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,513,851.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 9 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 2,902,339.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 259,280.7 мянган төгрөгийн, оны эхний үлдэгдлээс 191,078.6 мянган төгрөгөөр, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 41,755.0 мянган төгрөг бүрдүүлэхээр нийт 3,394,453.6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 719,776.8 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 20,547.6 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 59,010.1 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлыг 3,800.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 67,977.3 мянган төгрөгөөр,
- Тэтгэмж урамшууллын зардлыг 9,490.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн гэх мэт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 3,394,453.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 2,946,088.7 мянган төгрөгийг зарцуулж, 446,119.1 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,946,088.7 мянган төгрөг буюу 86.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	5,581.0	5,581.0	-	100.0
		2	80233- Хүүхэд хамгаалал	5,894.2	1,600.0	4,294.2	27.1
		3	80312- Сургалт семинар	4,035.1	4,035.1	-	100.0
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	11,486.9	4,737.0	6,749.9	41.2
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	126,902.7	112,669.9	14,232.8	88.8
		6	81806-Дотуур байрны үйлчилгээ	119,460.1	100,250.4	19,209.7	83.9
		7	81816- Хүүхдэд зэлтэй сургалтын орчин	48,198.4	48,198.4	-	100.0
		8	81823- Боловсролын багшийн сургалт	17,149.5	6,950.0	10,199.5	40.5
		9	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	6,985.8	84.3	6,901.5	1.2
		10	81834- Боловсролын стандарт сургалт	2,744,822.4	2,372,733.5	372,088.9	86.4
		11	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	11,856.8	9,964.0	1,892.8	84.0
		12	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	18,000.0	10,728.0	7,272.0	59.6
		13	81848-сурах бичгийн түрээс	3,800.0	3,764.8	35.2	99.1
		14	81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	11,000.0	5,511.6	5,488.4	50.1
		15	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	259,280.7	259,280.7	-	100.0
Нийт				3,394,453.6	2,946,088.7	448,364.9	86.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	216,324.7	216,324.7	НТШ
Нийт дүн		216,324.7	216,324.7	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Хүүгийн хишиг” ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 03-ний өдөр гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,257,403.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 22,574.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд нийт 28 төрлийн 159 мэдээллийг байршуулахаас ил тод, бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Бусад хууль тогтоомжтой холбоотой асуудал

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит “ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 905 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн үнэлгээг дутуу бүртгэсэн нийт 60.0 мянган төгрөгийн зөрчил илэрч бүртгэл тооцоог урьдчилан хянан баталгаажуулж, тайланд үнэн зөв тусгаж тайлагнах зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	60.0	1	60.0	100.0
Нийт дүн	1	60.0	1	60.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 75,248.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Худалдан авсан үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд урсгал шилжүүлгийн зардлаар бүртгэснээс үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүнг 75,129.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.
- Худалдан авсан 119.3 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг төлбөр хүлээн авагчийн нэрээр бус хамаарал бүхий этгээд, өөр аж ахуйн нэгжийн нэрээр орлого авсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 1,675.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Албан хэрэгцээнд зарцуулсан 1,675.3 мянган төгрөгийн шатахууны үнийг хувь хүний дансанд шилжүүлж тухайн орлогыг шатахуун түгээх байгууллагын нэрээр орлого авч бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шатахууны тооцоог зохих журмын дагуу гүйцэтгэж, төлбөрийг шатахуун түгээх байгууллагын дансаар дамжуулж байх.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хэршлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Худалдан авсан үндсэн хөрөнгийг МГ тайланд урсгал шилжүүлгийн зардлаар тусгаснаас үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ буруу илэрхийлэгдсэн	1	75,129.0			1	75,129.0	1	75,129.0				
Худалдан авсан бараа материалыг төлбөр хүлээн авагчийн нэрээр бус хамаарал бүхий этгээд, өөр аж ахуйн нэгжийн нэрээр орлого авсан	1	119.3			1	119.3	1	119.3				
Нийт	2	75,248.3			2	75,248.3	2	75,248.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны үнийг хувь хүний дансанд шилжүүлж тухайн орлогыг шатахуун түгээх байгууллагын нэрээр орлого авсан	1	1,675.3					1	1,675.3				
Дүн	1	1,675.3					1	1,675.3				

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.МӨНГӨНЧИМЭГ ТАНАА**

2025.02.25 № СЭА-2025/186/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны 8 дугаар сард сургууль байгуулагдсаны 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж, ААН, иргэд төгсөгчдөөс 67,861.0 мянган төгрөгийн бараа материал, 90,483.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хандиваар хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

СЭА-2025/186/НА-СТА-ТШЗ

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА

